



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хог, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.АСРАЛТ ТАНАА

2019.03.25 № 01/582
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гаалийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гаалийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2019\0325SAG32.Docx



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Гаалийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Асралт Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гаалийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 26-наас 2019 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал гүйцэтгэв.

Гаалийн ерөнхий газар 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/1731 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гаалийн ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

'Гаалийн байгууллага нь үндэсний хөгжлийн зорилтод хувь нэмэр оруулах, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх' гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг нь гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл гаргах, гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудал болно.

Гаалийн ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Гаалийн тухай хууль
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Шуудангийн тухай хууль

Тайлант хугацаанд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дараах эрхийн актуудыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үр дүнг үнэлэх аргачлал
- Гаалийн улсын байцаагчийн ажлын үр дүнг дүгнэх журам
- Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Гаалийн албаны тэргүүн дээд шагналын шалгуур, олгох журам
- Төлбөрийн хэмжээ тогтоох тухай
- Гаалийн итгэмжлэл олгох журам

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гаалийн ерөнхий газрын салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2014 оноос хойш нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандартын дагуу шинэчлэгдсэн ч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Гаалийн ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гаалийн ерөнхий газар санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Сангийн яамны төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг "Э-тайлан" програм хангамж ашиглажээ.

Гаалийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Гаалийн ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс 2018 онд харьяа орон нутаг дахь 4 гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 13 зөвлөмж өгсөн байна. Мөн харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилласнаар хугацаа хоцроож мэдээлэл оруулах асуудал эрс багассан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гаалийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Тухайн төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд төсвөөс санхүүждэг байгууллага учраас төсвийн зарцуулалт гол анхаарах асуудал гэж үзэн зардлыг суурь үзүүлэлтээр сонголоо.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Гаалийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 44,037.8 сая төгрөгийн 2.0 хувь буюу 880.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2.0 хувиар тооцсон нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй, эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 21 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 19 байгууллага аудитад хамрагдсан байна. Горхи мэлхий хад амралтын газар УТҮГ дуудлага худалдаагаар борлуулахаар төлөвлөгдсөнөөс 2018 онд үйл ажиллагаа явуулаагүй тул аудитад хамруулаагүй.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	17	2	1	
2	ТӨААН				1
	Дүн	17	2	1	1

Аудитаар харьяа 17 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн байна. Хараат бус аудитын компаниар гэрээгээр 4 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийсэн.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Гаалийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,967.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 79.2 хувь буюу 1,558.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1.3 хувь буюу 25.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.4 хувь буюу 106.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 14.1 хувь буюу 277.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар төсвийн шууд захирагчдын хэмжээнд 1,523.7 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 34.8 сая төгрөгийн алдааг залруулсан.

Гаалийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгуул-лагын ангилал	Үүнээс:											
		Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тосцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	39	408.8	6	25.5	11	106.0	22	277.3				
2	ТӨААН	-	-	-	-	-	-	-	-				
3	ТТЗ	-	-	-	-	-	-	3	-				
	Дүн	39	408.8	6	25.5	11	106.0	25	277.3				

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа зөрчлөөс материаллаг алдаа зөрчлийг дурдвал:

1. Дархан-Уул аймаг дахь гаалийн газар 29 ажилтанд тушаал, шийдвэргүй, нотлох баримтын шаардлагыг хангаагүй баримтаар 13.8 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон;
2. Дорнод аймаг дахь гаалийн газар
 - бараа материалын тайлангийн анхан шатны баримтыг хөтлөхдөө хүчингүй болсон маягтын дагуу хөтөлсөн, шатахууны тооцооллыг бодохдоо машины нормыг тооцоогүй, нягтлан бодогч хянаагүй нийт 21.8 сая төгрөг;
 - нүүрс тэвээрлэлт болон хамгаалалтын ажлын нийт 59.3 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа шууд худалдан авалтын арга ашигласан;
 - урсгал зардлаас туслах үйл ажиллагаа болох малчны цалинд 4.5 сая төгрөг зарцуулсан.
3. Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар 11.6 сая төгрөгийн их засвар болон хөрөнгийг зардалд шууд бүртгэсэн;
4. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар
 - урсгал засварын материалын 4.1 сая төгрөгийг байгууллагын жижиг мөнгөн сангийн дансаар дамжуулалгүйгээр, ажилтны цалингийн карт руу шилжүүлэн зарцуулсан;
 - цэвэр бохир усны зардлаас бохир соруулах зориулалтаар худалдан авсан 5.0 сая төгрөгийн шатахуунаас 1.2 сая төгрөгийн шатахууныг холбогдох албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр дотоод үйл ажиллагааны зардалд гүйлгэн зарцуулж, цэвэр бохир усны зардалд буруу тайлагнасан.
 - Тайлант онд нүүрс нийлүүлэх гүйцэтгэчийг сонгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тендерийн баримт бичиг боловсруулаагүй, техникийн тодорхойлолт, илчлэг чанарыг шалгуур болгон заагаагүй, хамгийн бага үнийн санал ирүүлсэн компанийг нүүрсний илчлэгийн шаардлага хангахгүй гэж хасан, дараагийн үнийн санал ирүүлсэн компанийг гүйцэтгэгчээр шалгаруулсан.

5. Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар тус байгууллагын албан хаагчдын орон сууцны 4.8 сая төгрөгийн бохирыг соруулах ажлын хөлсийг төсвийн хөрөнгөөс зарцуулсан;
6. Ховд аймгийн Булган дахь гаалийн газар 5.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлэн мөнгөөр өмч хамгаалах комиссын акт дүгнэлтгүй худалдан авч, бараа материалын дансанд бүртгэсэн.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцоноос 2 алдааг залрууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлгэхдээ 24.7 сая төгрөгийн устгах бичилт дутуу хийсэн, харьяа байгууллага аудит хийсэн санхүүгийн тайланг нэгтгүүлээгүйгээс 10.1 сая төгрөгийн зөрчил илэрснийг залруулав.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх 3 асуудлыг Менежментийн захидалд тусгалаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Маргаантай асуудлаас шалтгаалан 2018 оны дахин үнэлгээнд хамрагдаагүй газар, барилга байгууламжийн асуудлын шийдвэрлэлт болон дахин үнэлгээг авч үзнэ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Гаалийн ерөнхий газар 1 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 31,566.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 30,143.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,423.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудад улсын төсвөөс 30,143.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдохоос гүйцэтгэлээр 29,100.0 сая төгрөг олгогдож, олон улсын шинэ нисэх онгоцны буудал 2018 онд ашиглалтад ороогүй, үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар 1,043.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогджээ.

Хөрөнгө оруулалтын 9 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 1,842.2 сая төгрөгийн санхүүжилт гүйцэтгэлээр олгогдсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 1,423.5 сая төгрөг бүрдүүлэхээс гүйцэтгэлээр 1,761.2 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөг 23.7 хувь буюу 337.7 сая төгрөгөөр давуулсан байна.

Зардлын нийт гүйцэтгэл 28,978.1 сая төгрөг буюу 91.8 хувьтай байгаа нь Хөшигтийн хөндий шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад ороогүйгээс дутуу зарцуулагджээ.

Нэмэлт санхүүжилтээр төсвийн урамшуулал 393.7 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 15.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 58.5 сая төгрөг, олон улсын арга хэмжээ зохион байгуулахад зориулсан гадаадын байгууллагаас 6.0 сая төгрөгийн хандив нийт 473.2 сая төгрөгийн орлого орсон байна. Үүнээс 358.5 сая төгрөгийг зарцуулж, 114.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Гаалийн ерөнхий газар болон харьяа байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Гаалийн байгууллагын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 11 төрлийн тайлан, мэдээг 21 гаалийн газар, хороо, харьяа байгууллагууд нийт 2772 мэдээллийг байршуулан, 98 хувийн гүйцэтгэлтэй байна. Байгууллагын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ тайлан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгч нэр, хаяг, худалдан авах ажиллагааны тайлан, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, дараа жилийн төсвийн төсөл гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд нийт 93.3 хувийн биелэлттэй байна.

- Олон жил хуримтлагдсан барьцаа дансанд байгаа үлдэгдлийг өмнөх онуудын ажлын гэрээ, гүйцэтгэл, хүлээлцсэн акт зэргээс тендерийн хэмнэлт, захиалагчийн хяналтын зардал, алданги эсэх, гүйцэтгэгчид буцаан төлөх өглөг эсэхийг тодруулж улсын төсөвт төвлөрүүлэхээр байгаа үлдэгдлийг төвлөрүүлэх, гүйцэтгэгчид олгохоор байгаа үлдэгдлийг эзэн холбогдогчид нь олгох арга хэмжээ авах зөвлөмжийн дагуу барьцаа дансны үлдэгдлээс 16.5 сая төгрөгийн улсын төсвийн орлогын дансанд, 1.5 сая төгрөгийн техник хяналтын зардал дансанд төвлөрүүлж, гүйцэтгэгч байгууллагуудад 4.6 сая төгрөгийн барьцааг буцаан олгосон байна.
- Сангийн яамнаас авах 2014 болон 2017 онд үүссэн 14.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авах зөвлөмжийн дагуу оны эцэст бүрэн барагдсан байна.
- Төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийн дагуу газар, хороодын санхүүгийн тайланд өр авлага үүсгэхгүй байх тал дээр анхаарч хэтрэлт, хэмнэлт үүссэн зардалд дүн шинжилгээ хийн, зардлын бүлэг дотор хэтрүүлэн зарцуулсан газар, хороодын төсвийн төлөвлөлтөд хяналт тавьж, хүрэлцэхгүй байгаа зардлын тайлбар шалтгааныг тодруулан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг бэлтгэн Сангийн яаманд хүргүүлэн ажилласан

байна. Санхүүгийн ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх үүднээс харьяа гаалийн газар, хороодын нягтлан бодогч нарыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах" сургалтад хамруулж АЗ сертификат эзэмшүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гаалийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гаалийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цавэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гаалийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нийт салбарын хэмжээнд 2014 оноос хойш нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинэчлэлт өөрчлөлт хийгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Салбарын хэмжээнд ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн хууль, тогтоомж, стандарттай уялдуулан боловсруулж батлуулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулна.

3.2 Хураагдсан болон улсын орлого болгосон бараатай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Хураагдсан болон улсын орлого болгосон барааны өмнөх оны үлдэгдэл хэвээрээ, барааг борлуулж улсын төсвийн орлого болгох ажил удаашралтай байгаа нь ГЕГ-ын даргын 2008 оны 660 тушаалаар батлагдсан "Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам"-ын хэрэгжилт хангалтгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хураагдсан барааг удаан хадгалснаас үнэлгээ нь буурч улсын төсвийн орлого болгох дүнд хүрэхгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хураагдсан болон улсын орлого болгосон барааг борлуулж, улсын төсвийн орлого болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээрх журамд өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг ажиллаж байна.

3.3 Дотоод аудиттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,941.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,532.7 сая төгрөгийн алдааг залруулж, 25.5 сая төгрөгийн зөрчилд 7 акт, 106.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 277.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 20 зөвлөмж өглөө.

3.3.2 Эрсдэл:

Санхүү, нягтлан бодох бүртгэл зөв илэрхийлэгдэхгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Аудитаар илрүүлсэн зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байгаа харьяа байгууллагуудад 2019 онд санхүүгийн дотоод аудит хийж, хяналтыг сайжруулах, зөрчлийг багасгах талаар арга хэмжээ авах /Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар/

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу эрсдэл ихтэй байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,602,829.0	2,682,879.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	854,485.6	837,525.0
АВЛАГА	92,589.2	70,551.6
УРЬДЧИЛГАА	133,099.5	105,830.6
БАРАА МАТЕРИАЛ	2,522,454.6	1,668,972.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	121,444,480.0	110,758,105.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	121,444,480.0	110,758,105.0
Биет хөрөнгө	121,298,301.9	106,194,022.1
Биет бус хөрөнгө	146,178.1	4,564,082.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	125,047,108.9	113,440,984.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР	232,387.9	226,675.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	232,387.9	226,675.0
Өглөг	232,387.9	226,675.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	124,814,721.1	113,214,309.8
Засгийн газрын хувь оролцоо	124,814,721.1	113,214,309.8
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	65,798,906.9	70,229,324.4
Хуримтлагдсан үр дүн	54,930,747.0	36,877,588.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,085,087.1	6,107,399.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	125,047,108.9	113,440,984.9

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	64,181,943.0	34,822,355.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,495,348.4	3,800,904.5
Нийтлэг татварын бус орлого	12,802,953.2	3,800,453.5
Тусламжийн орлого	22,692,395.2	451.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,686,594.6	31,021,451.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	35,320,612.5	42,894,284.7
УРСГАЛ ЗАРДАЛ	34,817,674.7	42,894,284.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,498,912.1	39,715,245.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,312,055.3	19,458,388.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,045,175.3	2,335,356.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,845,543.1	2,072,065.2
Хангамж, бараа материалын зардал	436,571.6	607,208.9
Нормативт зардал	274,830.6	295,191.3
Эд хогшил, урсгал засварын зардал	435,254.6	592,574.0
Томилолт, зочны зардал	138,229.2	118,508.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,401,908.3	1,708,269.5
Бараа үйлчилгээний бусад зардал	6,609,344.3	12,527,683.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,318,762.6	3,179,039.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	502,937.7	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	28,861,330.5	-8,071,929.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,765,941.6	733,227.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	27,095,388.9	-8,805,156.6

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	31,974,003.6	33,378,467.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,138,593.9	2,356,142.4
Нийтлэг татварын бус орлого	3,138,593.9	2,356,142.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,835,409.7	31,022,325.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,928,477.5	31,167,884.0
УРСГАЛ ЗАРДАЛ	29,928,477.5	31,167,884.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,207,870.2	27,883,325.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,202,253.2	19,441,900.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,024,766.0	2,345,013.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,836,974.9	2,053,741.8
Хангамж, бараа материалын зардал	379,764.6	445,998.3
Нормативт зардал	473,169.7	133,461.3
Эд холшил, урсгал засварын зардал	1,238,276.5	859,389.5
Томилолт, зочны зардал	139,048.3	118,638.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,468,877.7	1,967,451.6
Бараа үйлчилгээний бусад зардал	444,739.4	517,731.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,720,607.2	3,284,558.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,045,526.1	2,210,583.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,466,450.0	2,227,544.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,466,450.0	2,227,544.2
Дотоод эх үүсвэрээр	1,466,450.0	2,227,544.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,466,450.0	-2,227,544.2
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	579,076.2	-16,960.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	275,409.5	854,485.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	854,485.6	837,525.0

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,723,525.8		97,723,525.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,626.0		8,626.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,732,151.9		97,732,151.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-12,819.7		-12,819.7
Тайлант үеийн үр дүн	27,095,388.9		27,095,388.9
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,814,721.1		124,814,721.1
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	124,814,721.1		124,814,721.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,248,004.1		-9,248,004.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,566,717.0		115,566,717.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,022,331.9		2,022,331.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,430,417.5		4,430,417.5
Тайлант үеийн үр дүн	-8,805,156.6		-8,805,156.6
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,214,309.8		113,214,309.8

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,566,541.9	28,978,108.0	2,588,433.9	91.8
УРСГАЛ ЗАРДАЛ	31,566,541.9	28,978,108.0	2,588,433.9	91.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,572,304.0	27,991,111.1	2,581,192.9	91.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,229,383.0	19,441,900.7	1,787,482.3	91.6
Үндсэн цалин	11,723,550.2	10,704,219.7	1,019,330.5	91.3
Нэмэгдэл	6,255,267.7	5,841,565.0	413,702.7	93.4
Унаа хоолны хөнгөлөлт	846,795.5	618,807.0	227,988.5	73.1
Урамшуулал	2,229,372.6	2,111,826.7	117,545.9	94.7
Гэрээт ажлын хөлс	174,397.0	165,482.3	8,914.7	94.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,547,742.7	2,345,013.2	202,729.5	92.0
Тэтгэрийн даатгал	1,811,845.9	1,623,696.1	188,149.8	89.6
Тэтгэмжийн даатгал	185,974.3	167,990.9	17,983.4	90.3
ҮОМШӨ-ний даатгал	148,779.3	156,658.5	(7,879.2)	105.3
Ажилгүйдлийн даатгал	37,194.8	39,242.2	(2,047.4)	105.5
Эрүүл мэндийн даатгал	363,948.4	357,425.5	6,522.9	98.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,151,580.2	2,053,741.8	97,838.4	95.5
Гэрэл, цахилгаан	1,292,709.4	1,232,367.1	60,342.3	95.3
Түлш, халаалт	585,679.8	561,107.4	24,572.4	95.8
Цэвэр, бохир ус	101,728.3	92,742.4	8,985.9	91.2
Байрны түрээс	171,462.7	167,525.0	3,937.7	97.7
Хангамж, бараа материалын зардал	448,443.9	445,998.3	2,445.6	99.5
Бичиг хэрэг	66,610.6	66,199.4	411.2	99.4
Тээвэр, шатахуун	234,024.0	234,677.4	(653.4)	100.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,828.9	43,130.9	698.0	98.4
Ном, хэвлэл	33,253.0	33,198.6	54.4	99.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,039.2	18,119.0	920.2	95.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51,688.2	50,673.0	1,015.2	98.0
Нормативт зардал	380,805.1	133,461.3	257,343.8	34.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,882.0	5,878.6	3.4	99.9
Хоол, хунс	32,175.0	32,171.2	3.8	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	352,748.1	95,411.5	257,336.6	27.1
Эд хогшил, урсгал засварын зардал	1,180,425.6	1,102,361.4	88,064.2	92.6
Багаж, техник, хэрэгсэл	235,452.8	211,893.9	23,558.9	90.0
Тавилга	126,866.2	63,971.0	62,895.2	50.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,621.3	25,878.0	743.3	97.2
Урсгал засвар	801,485.3	800,618.5	866.8	99.9
Томилголт, зочны зардал	166,479.6	118,638.5	47,841.1	71.3
Гадаад албан томилолт	18,446.3	16,896.9	1,549.4	91.6
Дотоод албан томилолт	148,033.3	101,741.6	46,291.7	68.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,008,597.7	1,956,975.2	51,622.5	97.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,380,761.0	1,355,646.4	35,114.6	97.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,368.2	18,289.7	1,078.5	94.4
Даатгалын үйлчилгээ	68,710.6	68,138.3	572.3	99.2
Тээврийн хэрэгслийн татвар	9,024.4	7,330.1	1,694.3	81.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,767.7	2,242.5	525.2	81.0

Гаалийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	158,825.4	158,748.6	76.8	100.0
Газрын төлбөр	7,677.7	6,961.4	716.3	90.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	351,462.7	339,618.2	11,844.5	96.6
Бараа үйлчилгээний бусад зардал	438,846.2	393,020.7	45,825.5	89.6
Бараа үйлчилгээний бусад зардал	39,850.0	30,769.0	9,081.0	77.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	398,996.2	362,251.7	36,744.5	90.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	994,237.9	986,996.9	7,241.0	99.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	74,082.9	74,082.5	0.4	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	74,082.9	74,082.5	0.4	100.0
Бусад урсгал шилжүүлэг	920,155.0	912,914.3	7,240.7	99.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	110,413.5	109,343.4	1,070.1	99.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	801,741.5	795,570.9	6,170.6	99.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000.0	8,000.0	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,566,541.9	28,973,806.9	2,592,735.0	91.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,143,054.7	27,212,649.3	2,930,405.4	90.3
Улсын төсвөөс санхүүжих	30,143,054.7	27,212,649.3	2,930,405.4	90.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,423,487.2	1,761,157.6	(337,670.4)	123.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,423,487.2	1,761,157.6	(337,670.4)	123.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,663.0	(4,663.0)	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	361.8	(361.9)	0.0

Хавсралт

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.03.25	Аудитын нэр: Гаалийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/2/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гаалийн ерөнхий газар	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нийт салбарын хэмжээнд 2014 оноос хойш нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинэчлэлт өөрчлөлт хийгдээгүй байна.		Зөвлөмж	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Д.Долгорсүрэн
2	Хураагдсан болон улсын орлого болгох барааны өмнөх оны үлдэгдэл хэвээрээ, барааг борлуулж улсын төсвийн орлого болгох ажил удаашралтай байна.		Зөвлөмж	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Улсын орлогын бараа хариуцсан гаалийн улсын байцаагч	Д.Долгорсүрэн Б.Одончимэг
3	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,932.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,523.7 сая төгрөгийн алдааг залруулж, 25.5 сая төгрөгийн зөрчилд 7 акт, 106.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 277.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 20 зөвлөмж өглөө.		Зөвлөмж	Төсвийн шууд захирагчид	Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газрын дарга нар
	Дүн				